



3. Арчилгаа маллагаа ба тэжээл.

Чийгийн улаан хорхойг 16-25°C хэмийн дулаанд байлгаж тэжээлийн орчинг сийрэгжүүлэн усалж байх шаардлагатай.

Хорхой амьдрах гол нөхцөл бол тэжээлийн орчны чийглэг юм. Чийг ихсэх, багасахыг хорхой маш эмзэг хүлээн авдаг бөгөөд бага чийгэнд маш эмзэг. Тэжээлийн орчны чийглэг 70-80 % байх хэрэгтэй бөгөөд 3-5 хоног саванд байлгасан 20-24°C хэмийн дулаантай усаар нарийн нүхтэй шүршүүр ашиглан услана. Хорхойг тэжээлд оруулаад хэд хоносны дараа тэжээлээ 3-5 см зузаантайгаар анхны далан дээрээ намж өгнө. 2 долоо хоногийн дараа хорхой тэжээлээ идэж дууссны дараа дахин тэжээлээ 5-7 см зузаантайгаар нэмнэ. Энэ маягаар 7 хоног бүр тэжээлээ нэмж далангийн өндөр 50-60 см болоход тэжээл өгөхөө зогсооно. Тэжээл өгөх давтамж нь хорхойны тоо, үржүүлж байгаа орчны дулаанаас хамаарна. 24 хэмийн дулаанд тэжээл хамгийн их хэрэглэнэ. Зуны улиралд голын бүлээн усаар юм уу борооны усаар услах маш тохиромжтой, хорхой маш сайн үржинэ. Тэжээлд хорхой анх оруулсан үеэс 3-4 сар өнгөрөхөд тэжээл бүрэн боловсорч сайн чанарын био буюу "амин" бордоо болсон байна. Чийгийн хорхой тэжээлд байхдаа агаар их шаардах тул тэжээлийн өндөр 20 см-ээс дээшилсэн үеэс эхлэн 2-3 см голчтой модон саваагаар эсвэл тусгай сэрээгээр тэжээлд нүх гарган агаар оруулж байх хэрэгтэй. Хорхой идэвхитэй ажиллагааныхаа үед тэжээлийн орчин дотроо гурван давхаргад хуваагддаг.



Нэгдүгээр давхарга буюу 5-7 см-ын зузаантай тэжээлийн давхаргаас хорхой байнга тэжээгдэж тэр нь тогтмол хугацаанд шинэ тэжээлээр нөхөгдөж байдаг.

Энэ давхаргад хорхойн тоо хэмжээ тэжээлд орохоос хамаарч өөрчлөгдөж байдаг. Дунд давхарга буюу 10-30 см зузаантай давхаргыг ажлын давхарга гэх бөгөөд ихэнх хорхой энэ давхаргад амьдарна. Гуравдахь давхаргад хорхойны үйл ажиллагаагаар "амин" бордоо хуримтлагдан тогтмол өндөрсөж байдаг.

4. Хорхойг гаргах, бордоог ялгах ажиллагаа:
Хорхойны тэжээл бүхэлдээ бордоо болсон эсвэл 1 ам метр талбайд ногдох хорхойны тоо 30-50 мянгаас давах үед хорхойнуудыг тэжээлээс гаргана. Ингэхийн тулд хорхойг хэдэн хоног тэжээл өгөлгүй өлсгөсны дараа талбайн гуравны нэгд 5-7 см зузаантай тэжээл шинээр өгөхөд хорхой тэр тэжээл руу нүүж орно. Тэжээлээ 2-3 хоног байлгаад нүүж орсон хорхойтой хамт ялган авна. Ийм ажиллагааг 3 долоо хоногийн туршид 3-аас доошгүй удаа давтан өсвөр хорхой болон өндгийг ялган авдаг. Үлдсэн хар бараан өнгөтэй хэсгийг хүрз, малтуураар цуглуулан авч 40 хүртэл хувийн чийглэгтэй хатааж, шигшин савлаж хадгална. Хатаасан "амин" бордоог -20°C хэмийн хүйтнээс +30°C хэмийн дулаанд 24 сар хадгалж болно. "Старатель" хэмээх чийгийн улаан хорхой маань хоногт өөрийн жинтэй тэнцүү "амин" бордоо үйлдвэрлэж 10-16 жил амьдардаг. Нэг хорхой жилд 1500 хорхой болон үрхдэг. 9-32°C хэмийн дулаанд ажиллах чадвартай.

Манай хаяг: Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жилсиг Төслийн Хотөлбөр, НУБ-ын Хөгжлийн Хотөлбөр, НУБ-ын байр, НУБ-ын судалж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14201, Монгол улс.

Утас: 976 (11) 327585 ext-1140, 70112883

Цахим шуудан: ganbaatar.band@undp.org

naranarav.gankhyag@undp.org



Алт өлборлолтод монгол усыг хэрэглэнээ гаргах тосолд хамрагдагчид зориулав

Био бордоо буюу ялзмаг хийх гарын авлага

Био бордоо буюу био ялзмаг гэж юу вэ?



Малын өтөг, бууцыг компостлох буюу биологийн задралд оруулсны дараа түүндээ чийгийн улаан хорхой оруулан идүүлж ялгадас байдлаар боловсруулан гаргаж авсан өндөр чанартай шим бордоог био ялзмаг гэдэг. Био ялзмагийг технологийн дагуу бэлтгэж ашиглах нь маш чухал. Малын бууцыг задалж боловсруулахгүйгээр шууд хэрэглэж болохгүй. Ялангуяа шинэхэн бууц нь хог ургамлын ургах чадвартай үрүүд, өвчин үүсгэгч бактери, мөөгөнцөр, хортон шавьжийн өндөг, авгалдай зэргийг агуулсан байдаг тул талбайд сөрөг нөлөөтэйгөөс гадна ургамалд шингэцтэй тэжээлийн бодисоор ядраг өтөг бууцнаас гаргаж маш сайн чанарын бордоог өтөг бууцнаас гаргаж авахад компостлоод чийгийн улаан хорхойгоор боловсруулах буюу "vermi-composting" аргыг хэрэглэдэг байна.



МОНГОЛ ЭКОЛОГИЙН
БОРДОО

Ямар ач холбогдолтой вэ?

Газар тариалангийн системд хөрсний ялзмагийн жил бүрийн алдагдлыг органик бордоогоор нөхөн сэргээж байх тохиолдолд л хөрс үржил шимээ хэвийн хадгална. Бүх төрлийн шим бордоонуудаас бууцан бордоо нь тэргүүн зэргийн ач холбогдолтой, хөрсөнд иж бүрэн нөлөө үзүүлдэг онцгой шинж чанартай бөгөөд ургамал болон хөрсөнд чухал шаардлагатай элементүүдийн эх үүсвэр болохын зэрэгцээ үржил шимээ алдаж элэгдэлд орсон хөрсийг сэргээх, хөрсний бүтцийг сайжруулахад онцгой нөлөөтэй. Тэрээр хөрс, ургамлын бүх шинж чанарт сайнаар нөлөөлж ургамлын хооллолт, фотосинтезийн үйл ажиллагааг сайжруулан микро биологийн олон процессийг идэвхжүүлж талбайн хөрсний бүтцийг сайжруулах, хөрсний ус, агаарын тохиромжтой горим бүрдүүлэх, ус барих чадварыг дээшлүүлэх, хөрсний ионуудыг барих, шингээх чадварыг нэмэгдүүлэх, хөрсний буферлаг чанарыг ихэсгэх гээд олон аерэг үйлчилгээтэй. Түүнчлэн хөнгөн механик бүтэцтэй хөрсийг бордоход чийг барих чадвар болон тэжээлийн бодисыг шингээн барих багтаамж эрс дээшлэх бөгөөд хөрсний дулаан, агаарын горимыг сайжруулж, физик ба физик-химийн шинж чанарт сайнаар нөлөөлж микрофлорын үйл ажиллагааг хүчтэй болгож, хүчиллэгийг бууруулж, ялзмагийг нэмэгдүүлдэг зэрэг олон талын сайн нөлөөтэй юм.

Яаж хийх вэ?



Бууцыг биологийн задралд оруулж тогтвортой органик материал болох бордоо гаргаж авахыг компостлох гэж ойлгож болно. Компостлох явцад дулаан ялгарч тэр

дулааны үйлчлэлээр элдэв өвчин үүсгэгч бичил биетнүүд болон хогийн ургамлын үрүүд устаж үнэр нь багасаж тогтвортой эцсийн бүтээгдэхүүн буюу бордоо бий болдог.

1. Компост буюу чийгийн хорхойн тэжээл бэлтгэх. Дулааны улирал эхлэхэд хамгийн сайн түүхий эд болох 1жил болсон малын бууцыг 80 см өндөртэй, 120 см өргөнтэй нуруу хэлбэрийн овоолго хийгээд усалсны дараа нийлэг хальсаар хучаад чийг, дулаан, агааржуулалтын горимыг тохируулах замаар биологийн задралд оруулж компостыг гаргаж авна. Мөн дотроо хэт халж шатахаас сэргийлэхийн тулд температур, чийгийг байнга хянах, задралыг жигд явуулах үүднээс эргүүлэн хөлий ажлуудыг хийнэ. Шинэ бууцыг хэрхэвч тэжээлд хэрэглэж болохгүй, Хорхой үхнэ.

"Старатель" хэмээх чийгийн улаан хорхойг Орхон аймгийн "Мүгээ" хоршооны ахлагч Я.Тоолой 2005 онд ОХУ-аас Монголд оруулж ирээд өсгөж сонирхсон хүмүүст нийлүүлж байгаа.



2. Компост буюу тэжээлдээ хорхойгоо оруулах. Чийгийн хорхой үржүүлэх, чанартай шим бордоо гаргаж авах энэ шат дамжлагад онцгой анхаарч бэлтгэлээ сайн базаах хэрэгтэй. Компостоо нарны гэрэл шууд тусахгүй орчинд (цементэн шалтай битүү байр байвал сайн) 15-20 см зузаантайгаар шалан дээр далан маягаар дэлгэж сайтар чийглэсний дараа чийгийн хорхойнуудаа оруулна. Чийгийн хорхойг тэжээлд оруулахдаа гадаргууд жигд хувиарлаж 1 ам метр талбайд 750-1500 ширхэг хорхой байхаар бодож хийнэ. Хорхой гэрлээс дайждаг тул агаар нэвтрүүлэх хар бараан бүтээлгээр бүтээх хэрэгтэй.